



“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2014 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар 2014/01

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:50 цагт эхлэв.

Хурлын ирц:

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дарга **Ц.Мандуулай** танилцуулснаар:

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссийн шийдвэр 1: “Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.3, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон АПУ ХК-ийн ТУЗ-ын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж байгаа шийдвэр, үүнд ҮЦТТХТ-өөс 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа, үнэт цаас эзэмшигчийн тодорхойлолтыг үндэслэн ТОГТООХ нь: 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 69,826,365 хувьцаа эзэмшдэг 178 хувьцаа эзэмшигч биеэр оролцож байгаа нь нийт хувьцаа эзэмшигчдийн 74,281,700 энгийн хувьцааны 93.99 хувь болж байгааг хурлын даргалагчид болон хуралд оролцогчдод мэдээллэсүгэй, 2. Компаний тухай хуулийн 69.1, АПУ ХК-ийн Дүрмийн 7.11 дэх заалтуудыг үндэслэн нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 93,99 хувь нь хуралд оролцож байгаа тул хурлыг хүчинтэйд тооцсугай.”

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга **Ч.Ариунсан**: АПУ ХК-ийн ТУЗ-ийн 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай тогтоолд зааснаар Хурлын даргаар томилогдсон АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэгийг** индэрт урилаа.

Хурлын дарга **Ц.Эрдэнэбилэг** ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын дарга “хэлэлцэх асуудал”-ыг танилцуулах
 - Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
2. Хэлэлцэж байгаа асуудлуудад тус бүр холбогдсон асуулт, хариулт
3. Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах
4. Санал хураалт явуулах

5. Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах
6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах
7. Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах
8. Хурлыг хаах

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 1-рт “Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулан хэлэлцэж батлах”

Танилцуулсан нь:

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Хуралд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэдээ мэндчилгээ дэвшүүлэн АПУ ХК нь бүх төрлийн шингэн хүнсийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүрэгдэг “Бид амьдралыг шимтэй болгодог: шалгарсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд, шилдэг ажлын байрыг ажилчдад, үйл ажиллагаандаа сайн засаглал, ногоон үйлдвэрлэлийг, хөрөнгө оруулагчдад ашгийг болон улс оронд хөгжлийг авчирна.” гэсэн эрхэм зорилго бүхий байгууллага бөгөөд өнгөрсөн 2013 он нь улс орны нийгэм, эдийн засгийн хувьд хүнд жил байлаа, гэвч бид урдаа тавьсан зорилтондоо цаг хугацаанд нь хүрэх, бүтээгдэхүүний нэгжид оногдох өртөг зардлыг хэрхэн зөв хувиарлах, өрсөлдөөнийг зөв тооцолж бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмжид анхааран хэрэглэгчдэд хүргэх, хэрэгжүүлж буй төслүүдийг цаг хугацаанд нь амжилттай дуусгах зэрэг олон ажлуудыг хийж ажиллалаа.

- АПУ компани 2013 онд 947 ажилчидтай, 106 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлэн, нийгмийн хариуцлагатай байж, хэрэглэгч, хамтрагч, түншүүд болон хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын итгэлийг биелүүлэн ажиллаа. АПУ компани 2013 онд бизнесийнхээ үйл ажиллагааг хэвийн тасралтгүй, тогтвортой явуулахын зэрэгцээ, хөрөнгө оруулалтын цогц бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж буй ажлынхаа хүрээнд дэлхийд тэргүүлэх байгальд ээлтэй, хүнсний аюулгүй байдлыг ханган, хүний хөдөлмөрийг хөнгөвчилөх чиглэлээр техник технологийн шинэчлэлийг хийж ажилласан. 2013 онд нийт 105.8 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 102.8 сая литр бүтээгдэхүүн борлуулан, 338.3 тэр бум төгрөгний борлуулалтын орлоготой, 49.4 тэр бум төгрөгний хөрөнгө оруулалтыг хийж, 4 тэр бум төгрөгний цэвэр ашигтай ажилласан байна. Энэ нь түрүү жилийнхтэй харьцуулбал тодорхой хэмжээний уналт хийсэн ба энэхүү уналт болоход нөлөөлсөн хүчин зүйлүүдийг бид та бүхэнд дараагийн хэсэгт тайлбарлах болно.
- Шинээр олон нэр төрлийн бүтээгдэхүүн гаргасан ба олон бүтээгдэхүүнийг шинэчлэн гаргасан байгаа. Шинэ пивоны үйлдвэрийг ашиглалтанд оруулан бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэн ажилласан. EBRD, Credit Suisse

банкуудаас төслийн зээлийн санхүүжилтыг авсан. АНУ-н зах зээлд Соёмбо брэндээр эхний бүтээгдэхүүнээ гарган экспортын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан.ERP систем нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тухайн системийн харьцуулсан судлагаануудыг хийн, дотооддоо одоогийн нөхцөлд мөшгөлтийн тогтолцоо, кодчилолыг сайжруулсан, бизнес процессийнхоо шинжилгээг хийн ажиллаж байна. Та бүхний мэдэж байгаагаар шинээр ашиглалтанд орсон Шар айрагны үйлдвэртээ Германы Мьюнхений алдарт Кальтенберг шар айргийг албан ёсны лицензээр анх удаагаа Монголдоо үйлдвэрлэсэн нь төслүүдийн зарим үр өгөөжийг илтгэж байгаа болно. Мөн Бүрэн автомат агуулахыг ашиглалтанд оруулан ажиллаж байна. ISO болон дотоод хяналтын тогтолцооны ажлуудыг амжилттай үргэлжлүүлэн ажиллаж байна.

- Мөн үйл ажиллагааны явцад тулгарч буй дараах бодит эрсдлүүд байна. Үүнд: Архи, согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төсөл, Чингис хаан бэлгэдлийг хэрэглэх, ашиглах журмын тухай хуулийн төслүүд УИХ-д хэлэлцэгдэхээр танилцуулагдаж байна. Эдгээр хуулиас хэтэрхий нэг талын эрх ашгийг барьсан популист хандлага илт харагдаж байна. Нийт хувьцаа эзэмшигчид та бүхийн тус хуулиудын төсөлд өөрсдийн санал бодлоо илэрхийлж, дуу хоолойгоо илэрхийлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Мөн гол эрсдлийг дагуулж буй Валютын ханшны өсөлт, тогтворгүй байдлаас бүтээгдэхүүн тус бүрт төлөгдөж буй онцгой албан татварын хэмжээ, Экспортын үйл ажиллагааны татварын эрсдэл, түүхий эд материалын үнэ өртгийн өсөлтөөс бүтээгдэхүүний өртөг өсөж байгаа боловч үнээ нэмж чадахгүй байдал үүсээд байна. Бид бизнес төлөвлөгөөгөө хийхдээ долларын ханшийг 1356 тооцож зардлуудаа тооцсон, тухайн үед тухайн үед буюу 2013 онд Монголын Улсын Засгийн газар төсөвтөө нэг ам.долларыг 1332 төгрөгөөр суулгасан байсан боловч бодит байдал өөр байлаа.
- Хөрөнгө оруулалтын хувьд: АПУ Ложистик төв, Шинэ шар айрагны үйлдвэр, Шинэ сүүний үйлдвэр, Сүү цуглуулах цэг, Саалийн үнээний ферм гэсэн төслүүдийг хэрэгжүүлж байгаагаас Ложистик төв буюу иж бүрэн автомат агуулах, Шар айрагний үйлдвэр маань 100 хувь ашиглалтанд орсон байгаа. Сүүний үйлдвэрийн төсөл одоогоор 80 хувийн гүйцэтгэлтэй ба шинэ сүүний үйлдвэр маань салбартаа хувьсгал хийсэн гэж ойлгож байна. Анх удаа хүүхдэд зоориулсан “Маамуу” брендийг хэрэглэгчдэд хүргэсэн, үхрийн цэвэр сүүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа “Сайн” брендыг танилцуулана, мөн сүү бэлтгэлийн чиглэлээр сүү цуглуулах цэг, үхрийн ферм байгуулан ажиллахаар ажиллаж байгаа. Ийнхүү тайлант жилд 49.4 тэр бум төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн ба энэ нь нийт он дамнуулан оруулсан хөрөнгө оруулалт нь 120 орчим тэр бум төгрөгний хөрөнгө оруулалтын нэг хэсэг юм. Үндсэндээ нийт 190 тэр бум төгрөгний хөрөнгө оруулалтыг хийхээр төсөвлөсөн байгаа.

- Нийт орлого үр дүнгийн хувьд:Цэвэр борлуулалтын орлого нь 193.7 тэр бум төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 138.9 тэр бум, нийт ашиг нь 54.7 тэр бум, үйл ажиллагааны зардал 34.3 тэр бум төгрөг ба үйл ажиллагааны ашиг нь 20.4 тэр бум төгрөг байна. Мөн хаалтанд дотор тэмдгэлсэн 15.441 тэр бум төгрөг бол үйл ажиллагааны бус ашиг алдагдал гарсан ба энэ нь долларын ханшны зөрүү бөгөөд бид ханшийн тэгшитгэл хийж энэ тооцоог гаргаж ирсэн. Мөн долларын ханшны зөрүүнээс экспортын түүхий эд материалын үнэ өссөн тул 21-22 тэр бум төгрөгний бодит алдагдалыг хүлээсэн байгаа. УИХ-аас Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрслөлт оруулах хуулийн төсөл хэлэлцэгдээр бэлтгэж байгаа бөгөөд ерөөс Монгол Улсад хийгдэж буй төлбөр тооцоо, татвар, хураамж, төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх заримтай зөрчилдсөн тухай асуудал яригдаж байгаа ба онцгой албан татварыг тооцоходоо төгрөгт шилжүүлэн бодох тухай төсөл явж байгаа болно. Харамсалтай нь төлбөр тооцоог төгрөгөөр хийх хууль хэрэгжихгүй байна. Ингээд татварын дараах ашиг нь 4.024 тэр бум төгрөг байна. Онцгой албан татварын хувь хэмжээний 2 дахин өссөн хуучин 1 литр тутамд 2 ам.доллар төлж байсан бол 4 ам доллар болсон, вальтын ханшны зөрүү зэргээс компаниас улсад төлсөн татварын хэмжээ 1.6 дахин өсгөж нийт 170 тэр бум төгрөгний татвар төлсөн байна. Энэ нь улсын хэмжээнд төлсөн татвар төлсөн хэмжээгээрээ Эрдэнэт үйлдвэрийн дараа буюу 2 дугаарт жагссан татвар төлөгч болсон байна. Орлого Үр дүнгийн төлөвлөгөө, Татварын дараах ашиг яах ч арагагүй бууж эхэлж байгаа. ТУЗ маань цаг үеийн байдалд яаралтай арга хэмжээ авч олон удаа ээлжит болон ээлжит бусаар хуралдаж, Гүйцэтгэх захиралд тухай бүр үүрэг даалгавар өгч ажиллаж байгаа. 2014 он гараад бизнес төлөвлөгөө 85 хувийн биелэлттэй явагдаж байгаа ч цаг үеийн байдлаас буухаа магадлалатай юм.
- Бидний үйл ажиллагаанаас зах зээлд эзлэх өсөлтөө 2 хувьтай өсгөсөн байгаа. Зах зээлд эзлэх хувийг тэд гэж хэлэхэд төвөгтэй бөгөөд багцаа тооцоо гаргаж байгаа. Архи пивоны зах зээлийн судалгааг хийж 2013 онд архины зах зээлд 66 хувь, пивоны зах зээлд 44 хувийг эзлэж байсан. Өнгөрсөн онд 46 хувьтай байсан ба бага зэрэг буурч байгаа боловч нөгөө талдаа борлуулалтын хэмжээ өссөн байгаа энэ нь шинэ үйлдвэрийг ашиглалтанд оруулах явцад ОХУ-ийн ПЭТ-тэй шар айрагны зах зээлийг бага зэрэг алдсан байна. Сүү сүүн бүтээгдэхүүний салбарт шинээр үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүдийг танилцуулахын зэрэгцээ хувьцаа эзэмшигч та бүхэн гэр бүл, найз нөхөддөө өөрсдийн бүтээгдэхүүнийг танилцуулан сурталчилахыг хүсье.
- 2014 онд бид дараах зорилтод хүрэхээр төлөвлөж байна. 2014 он бол бизнес эрхлэгчдийн хувьд хүнд, эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй орчинд

ажиллах болно. Бид ирэх онд 136 нэр төрлийн нийт 122.6 сая литр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэх, 116.1 сая литр бүтээгдэхүүн борлуулах, нийт борлуулалтын орлогыг 426.1 тэр бум төгрөгөд хүргэх, хөрөнгө оруулалтын зардалд 69.9 тэр бум, татварын дараах цэвэр ашигийг 2.9 тэр бум төгрөг хүргэх зорилт тавьж бизнес төлөвлөгөөгөө ТУЗ-өөр батлуулаад байна. Компанийн хэмжээнд Засаглалыг сайжруулах, Эрсдлийн удирдлага, Төсөв санхүүн бодлого зэрэг 7-8 гол хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллах болно. Макро түвшинд эрсдлүүд байгаа тул зардлаа хэрхэн хэмнэж болох талаар 3 шаттай хямралыг даван туулах төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллаж байна, ач холбогдлоор ангилан зарим төслүүдийг царцаасан байгаа.

- Ноогдол ашиг тараах тухай: АПУ ХК-ийн хувьцааны үнэ 4200 төгрөг байгаа байх, одоогоор компани зах зээлд 300 тэр бум орчим төгрөгөөр үнэлэгдэж байна. 2013 онд хувьцаа эзэмшигчдэд 6.6 тэр бум төгрөгний ноогдол ашиг тараахаар ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Хэдийгээр ашиг 4.02 тэр бум төгрөг байсан ч компанид хуримтлагдсан ашиг байсан тул 6.6 тэр бум төгрөг буюу нэгж хувьцаанд 90 төгрөгний ноогдол ашиг тараах боломжтой гэж үзсэн ба нөгөөтэйгүүр энэ жил АПУ ХК-ийн 90 жилийн ойн баяр болж байгаа тул энэ тоог билэгшээсэн юм.

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга **Ч.Ариунсан**: 2013 оны болон цаашдын үйл ажиллагааны тайланг танилцуулсантай холбоотой асуултыг асуугаад явья, хувьцаа эзэмшигчдээс асуулт байвал асууна уу?

Асуусан нь:

Асуулт 1 хувьцаа эзэмшигч **Б.Алтанцэцэг**: Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохор ирсэн та бүхэнд баяр хүргье. Компанийн нийт хөрөнгө оруулагчид, 1000 гаран ажилтан ажиллагсадын хүч хөдөлмөрийн дүнд компанийн маань үйл ажиллагаа сайн, сайхан ахицтай байгаа нь харагдаж байна. Гэхдээ онцгой татварыг нэмж үйл ажиллагааг унагааж байгаад хувьцаа эзэмшигч хүний хувьд гомдолтой байна, бусад хувьцаа эзэмшигчид ч мөн надтай санал нэг байгаа байх. Яагаад онцгой албан татварыг нэмээд байдаг юм бэ, онцгой албан татвар төлөгчидөд ял үрүүлж байна. Улсад 170 тэр бум төгрөгний татвар төлсөн гэж байна. Онцгой албан татвар төлөгчдөд ял үрүүлж байна шүү дээ. 2 ам.доллар байсан татварыг 4 болголоо, биднээс мөнгө дээрэмдэж, дээрлэхэж авч байна. Бид онцгой албан татварын ял үүрч байна. Хэрэв татвар нэмэгдээгүй байсан бол бид хувьцааныхаа ашгийг авах байсан, хувьцааныхаа үр ашгийг аваад амьдрал ахуйдаа хэрэглэмээр, орон байртай болмоор л байна шүүдээ. Энэ талаар хувьцаа эзэмшигчид бид нийлж хэлж яримаар байна, санал бодлоо илэрхийлмээр байна, энэ байдлын эсрэг тэмцэхийг өнөөдөр би та бүхэнд уриалж байна. Хууль тогтоол шийдвэрт нь нөлөөлөх хэрэгтэй.

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Энэ надад зориулж биш, УИХ-д хандаж хэлсэн үг байна. Бид онцгой татвар 1 литрт 4 ам доллар болж байгааг зөвшөөрье, хувь хэмжээний асуудал бол хуулийн дагуу гэж үзэж байна. Харин Төлбөр тооцоог төгрөгөөр хийх хуулийн дагуу онцгой албан татварыг төгрөгөөр тооцож авах л ёстой гэдэг зарчим дээр арга хэмжээ авах ёстой гэж үзэж байна. Бидэнд 1000 орчим ажилтан, болуулалтын сүлжээгээр дамжуулаад 800 гаран ажилтан ажиллагсад байгаа бөгөөд нийт 4000 гаран хувьцаа эзэмшигчид бид нийлээд энэ талаар ярих, нөлөөх, эрх ашгаа хамгаалах боломж байгаа гэж үзэж байна.

Асуулт 2 хувьцаа эзэмшигч **Ү.Цогзолмаа**: Санхүүгийн албанаас асуумаар байна. Надад АПУ ХК-ийн сүүлийн 4 жилийн тайлан дээр хийсэн шинжилгээ байна. 2013 оны байдлаар компанийн дампуурлыг үнэлээд үзэхэд дампуурах эрсдэл өндөр байна гэж гарсан байна. Санхүүгийн мэдлэгтэй хүн харахад ойлгомжтой байна. Дампуурах эрсдэл их байгааг тайлбарлаад өгөх хэрэгтэй байна. Өр төлбөрөө төлөх чадамжгүй болсон байгаа харагдаж байгаа тул энэ талаар тайлбар хийнэ үү?

АПУ ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал **Б.Түвшин**: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. Дампуурал гэж хүндрүүлээд байх шиг байна. Долларын ханшны өсөлтийн зөрүүнээс 15 тэр бум төгрөгийн бодит бус алдагдал гарсан гээд орлого үр дүнгийн тайланд орсон байгаа тухай санхүүгийн ханшийн тэгшитгэл хийж гаргасан тооцоо болох тухай, бодит мөнгөөр гараагүй алдагдал болох тухай сая Гүйцэтгэх захирал танилцуулсан байгаа. Бид дээр дурдсан зээл болох 89 сая долларыг 5-7 жилийн дотор цувруулан төлнө. Хэрэв онцгой албан татварыг төгрөгөөр тооцох юм бол энэ зээлийг бид 3 жилийн дотор хугацаанаас нь өмнө төлөх боломжтой тоо. Энэ бол гадаад зах зээлээс хамаарахгүй, УИХ-дээр асуудлыг шийдэх, улсын хэмжээнд дотооддоо шийдвэрлэх бүрэн боломжтой асуудал юм. Нөгөөтэйгүүр ашгаар нь тооцоод асууж байх шиг байна, тайлбар хийе. Бид 4 тэр бум төгрөг дээр 15 тэр бум төгрөгний ашиг нэмэх нь буюу нийт 19 тэр бум төгрөгний ашигтай ажилласан байгаа, бид Санхүү Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу ханшийн тэгшитгэл хийдэг учраас 15 тэр бум төгрөгний ханшийн бус алдагдлийг гаргасан байгаа юм. Бүх төрлийн аудитын болон тайлангийн шинжилгээ, харьцаануудаас харахад Энэ бол нийт үр өгөөжид нөлөөлсөн нөлөөлөл болохоос бус дампуурлын болон тогтвортой байдлын хэмжээнд хүрэхээр үзүүлэлт биш юм. Дэлхийн 4 том аудитын компанийн нэг KPMG аудитаас хийсэн дүгнэлтээр 2013 оны жилийн дүгнэлтээр АПУ ХК-ийг эрсдэлгүй, тогтвортой байдлын үзүүлэлт сайн гэж үнэлсэн байгаа. 2013 оны үзүүлэлтээс харахад бүх тоо хэмжээ, үнийн дүн давж биелэсэн ба ганцхан тооцоолол зөрсөн нь онцгой албан татварын хувь хэмжээ юм. Өөрөөр хэлбэл төрд төлөх ёстой онцгой албан татварыг өөрийн борлуулалтын орлогоос хасч төлсөн гэсэн үг.

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Долларын ханшны зөрүү их байвал мэдээж алдагдалтай энэ талаар анхаарч ажиллах болно.

Асуулт 3 хувьцаа эзэмшигч **Ү.Цогзолмаа**: Дүгнэлтээс харахад 2013 онд төлөвлөлтөнд гүйцэтгэл нь хүрэхгүй байхад хэтэрхий их хөрөнгө оруулалт хийгээд байх нь зөв үү, энэ хэр үр өгөөжтэй вэ?

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Хөрөнгө оруулалт, Бизнесийн өгөөжийг 1 жилд харж тооцоолдоггүй, бизнесийн өгөөжийг 10-20 жилийн туршид харах хэрэгтэй. Өнөөдөр их зардалтай байвч ирээдүйд өгөөжөө өгнө. Жишээ нь Ложистик төвийг барьснаар бид ирээдүйд гарч болох агуулахын зардлуудыг хэд дахин хэмнэсэн байх жишээтэй. Ганц санаа зовоож байгаа зүйл нь ханшийн өсөлт, онцгой албан татварыг ам.доллараар тооцож авч байгаа явдал байна.

Асуулт 4 хувьцаа эзэмшигч **Д.Баярдалай**: Миний сонссоноор түүхий эд, бараа материал, шошгийг хятадаас авдаг гэсэн, дотоодоос авах боломжтой юм биш үү. Ингэснээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, валютын ханшны өөрчлөлтөд орохгүй, тээврийн зардал хэмнэнэ. 90 тэр бум төгрөгний импортын худалдаа хийх биш, дотоодийн зах зээлээс худалдаа хийхийг 30 хувь биш 50 хувьд хүргэх боломж байдаг юм болов уу.

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Дотоодын үйлдвэрлэлийг дэмжихтэй бүрэн санал нийлж байна. Манай үйлдвэрт өндөр түвшний тоног төхөөрмжүүд тавигдсан байдаг ба энэ нь чанартай түүхий эд материалыг хэрэглэхийг шаарддаг, энгийн шошго гэхэд нарийн шаардлага тавигддаг, Монголд Мон лабел ХХК гэх мэт шошго үйлдвэрлэдэг компаниуд байдаг, Үйлдвэр худалдааны яамнаас ч мөн бидэнд дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг санал болгодог, гэвч харамсалтай нь одоохондоо манай дотоодын үйлдвэрлэл манай үйлдвэрийн чанарын шаардлагыг хангадаггүй тал бий. Цаасан хайрцаг, нэгтийн хайрцгуудыг дотоодын зах зээлээс авдаг цаашдаа дотоодын зах зээлийн худалдааг нэмэгдүүлэх хэрэгтэй. Бид ISO стандарт, хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг хангаж ажиллах, нийлүүлэгчдэд шаардлага тавих хууль ёсны хэрэгцээ байдаг, цаашдаа хамтдаа хөгжөөд явна гэдэгт итгэлтэй байна.

АПУ ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал **Б.Түвшин**: Долларын ханш нь борлуулалтын орлого, зээл зээлийн хүү, худалдан авалт нөөлөлдөг үзүүлэлтүүд байгаа. Таны асууж байгаа түүхий эд материалд нөлөөлж байгаа долларын ханшийн үзүүлэлт буюу 8.5 тэр бум төгрөгийн алдагдлыг бид ямар нэгэн төр засгийн байгууллагад гомдоллохгүй байгаа, хүлээн зөвшөөрч байна. Энэ нь тэртэй тэрэнгүй төгрөгийн ханшны сулрал, доллар валютын өсөлтөөс шалтгаалсан гадаад зах зээлийн хүчин зүйл юм. Харин онцгой албан татварыг төгрөгөөр бус доллараар авч байгаа асуудлыг дотооддоо шийдвэрлэж болох, засагдаж болох хүчин зүйл юм шүү гэдгийг ойлгох нь чухал.

Асуулт 5 хувьцаа эзэмшигч **Ард капитал групп ХХК**-иас: EBRD, Credit Suisse-ээс зээл авсан гэнэ, тэдний шаардлагаар ямар ямар харьцаануудыг барьж ажилладаг вэ, үйл ажиллагааны болон санхүүгийн харьцаануудын хувьд хязгаарлалт тавьдаг ямар нэг хязгаарлалтын асуудал гэрээнд байна уу, онцгой нөхцлүүд байна уу?

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын харьцаанууд бүгд тавигдсан шаардлагын дагуу тодорхой харьцаатай байгаа, зарим том хувьцаа эзэмшигчдийн хувьд ноогдол ашиг авах эрхгүй байгаа. EBRD, Credit Suisse банкуудаас зээл авч чадаж байгаа байгууллагууд Монголд ховор байгаа, байвал ганц, хоёрхон байгаа байх, АПУ ХК бол тэдний шаардлагуудыг бүрэн хангадаг.

АПУ ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал **Б.Түвшин**: Төлбөрийн чадварын болон тогтвортой байдлын үзүүлэлийг бид хангалттай хангаж байгаа.

Асуулт 6 хувьцаа эзэмшигч **Ц.Самданпунцаг**: Энд тэндгүй бүтээгдэхүүний шил хаягдсан байх юм. Шилийг дахин ашигладаг уу, хаягдал шил авч байгаа үнэ нь бага байна, шил хаягийг буцаан хэрэглэхгүй, нууцлалыг хангаж ажиллахгүй байгаагаас хуурамч архи ихэснэ шүү дээ.

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Зөв асуулт асуулаа, Монгол улсад манай үйлдвэрийн стандартын байтуугай энгийн шил үйлдвэрлэдэг үйлдвэр байдаггүй, бид аль болох бүтээгдэхүүнийхээ шилийг дахин ашиглах бодлого барьдаг. Бид 200 гаран ажилтантай Дипод ХХК-тай хамтрач ажилладаг ба тус компани нь хаягдал шил аваад угаагаад буцаагаад манайд худалдаалдаг юм. Бид эргэлтийн шилний харьцааг 70:30-ийн харьцаатай буюу дахин ашиглах шил 70 хувь, шинээр импортлох шилийг 30 хувьд барьж үйлдвэрт хэрэглэхийг эрмэлздэг.

Асуулт 7 хувьцаа эзэмшигч **Д.Намхай**: Хувьцааны ашиг орлого, шимтгэлийг ямар журмаар өгдөг юм бэ, хэдэн оноос өгч эхэлсэн байна. Би одоо 1000 хувьцаатай. 1995 онд өгөхөд нь авсан юм, би 5000 төгрөг 2 удаа авч байсан.Заримийг нь зараад одоо надад 1000 ширхэг хувьцаа байгаа ноогдол ашгаа яаж авах вэ? Анх 7000 хувьцаа өгсөн түүнээс хойш ягаан тасалбар, хувьцаа юу болж байгааг би мэдэхгүй байна.

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Сүүлийн 5 жилийн ноогдол ашиг хувиарлалт сайн хийсэн. АПУ ХК бол ноогдол ашиг харьцангуй сайн тараадаг компани гэж боддог. Та өөрийн асуудлыг хуулийн зөвлөхөд танилцуулан зөвлөгөө авна уу. Хуулийн зөвлөх н.Намхай гуайн асуудлыг тодруулаад эргээд надад мэдэгдэнэ үү.

Асуулт 8 хувьцаа эзэмшигч нэрээ хэлээгүй иргэн: Хувьцаагаа гадаадад гаргана гэсэн юу болж байгаа вэ?

Хурлын дарга, АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: Гадаадын хөрөнгийн биржид хувьцаа гаргахаар нь одоогоор банкнаас зээл авснаас өндөр эрсдэлтэй байгаа тул, түр хугацаанд хойшлуулсан байгаа ба ирээдүйд одоогийн авсан зээлийн өгөөжөөр комданийн үнэ цэнийг өсгөснөөр IPO гаргах бодлоготой байгаа-гэснээр асуулт хариулт өндөрлөж хурал цааш үргэлжлэв.

Танилцуулсан нь:

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга **Ч.Ариунсан**:

- Бидний хэлэлцэх асуудлын эхэнд буй АПУ ХК-ийн 2013 оны санхүүгийн тайланд KPMG Аудит ХХК аудитын компани аудит хийж 2014 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр тайлан, дүгнэлтээ ТУЗ-д танилцуулсан ба АПУ ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, баримт тайлан нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын санхүүгийн бүртгэл, тайлагналын стандартад бүрэн нийцсэн болохыг баталгаажуулсан. Мөн АПУ ХК-ийн гүйцэтгэх удирдлага, компанийн хамт олон 2013 онд макро эдийн засгийн таагүй орчноос үүдэлтэй сорилтыг даван туулж, бизнес төлөвлөгөөгөөр тавигдсан зорилго, зорилтуудыг биелүүлэхээр шаргуу ажиллан, үүргээ хангалттай биелүүлсэн хэмээн ТУЗ дүгнэсэн болно.
- Хурлаар хэлэлцэх 2,3-р асуудлын талаар тайлбар хийвэл ТУЗ-ын гишүүдийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох байгаа. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн гишүүн Александр Сильваши нутаг буцаж удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон байгаа. Одоогийн ТУЗ нь кумулятив аргаар сонгогдсон тул бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахын тулд бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, дахин сонгууль явуулах ёстой байдаг /Компанийн тухай хуулийн 77.3/ бөгөөд шинээр нэр дэвшигч 2 гишүүний танилцуулгыг хийв. Үүнд:

Ердийн гишүүнд нэр дэвшигч **Трэвис Хамильтон**:

Мэргэжил: Санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага

Төгссөн сургууль: Мельбурны Их Сургууль, Австрали улсын Компанийн Захирлуудын Хүрээлэн

Ажлын туршлага:

-2011-одоо Хан Инвестмент х/о сан, Гүйцэтгэх захирал

-2004-2011 Хельветика х/о сан, Швейцари улс, Борлуулалт хариуцсан захирал

-2002-2004 Кредит Свисс банк, Менежер

Бусад

-Монголын Бизнесийн Холбоо (Сингапур), Ерөнхийлөгч

-Австрали Монголын Бизнесийн Зөвлөл, ТУЗ-ийн гишүүн

Хараат бус гишүүнд нэр дэвшигч **Карло Радикати:**

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Ажлын туршлага:

1985 оноос хойш архи, согтууруулах ундааны салбарт ажиллаж байгаа.

“Русский Стандарт” архийг олон улсын тавцанд гаргасан туршлагатай.

-Одоо Хувиараа бизнес эрхэлж буй

-2008-2012 Русский Алкоголь Групп, Ерөнхий захирал

-2007-2008 Русский Стандарт компани, Гүйцэтгэх захирал

-1985-2007 Бакарди Мартини Групп, Хангамжийн менежер – ОХУ дахь салбар компанийн Ерөнхий захирал

Танилцуулсан асуудалтай холбоотой асуулт байгаагүй тул хэлцсэн 1.Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн томъёоллоор санал хурааж батлах; 2.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг мөн зөвшөөрсөн, татгалзан, түдгэлзсэн гэсэн томъёоллоор санал хураан шийдвэрлэх; 3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлуудаар нэр дэвшигч тус бүрт кумулятив аргаар санал өгч сонгохоор хураалт эхлэв.

Кумулятив аргаар хэрхэн санал хураах талаар Тооллогын комиссийн дарга Ц.Мандуулай танилцуулав.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга **Ц.Мандуулай:** Санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. “Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах” асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/	
тоо	хувь	тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
74,287,700	93,99	69,810,659	99							1400	0,002

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны **69,810,659** ширхэг хувьцаа буюу **99 хувь**, Татгалзсан – санал байхгүй, Түдгэлзсэн 1400 ширхэг хувьцаа буюу

0,002 хувь байна. Саналын эрхийн 12 292 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/	
тоо	хувь	тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
74,287,700	93,99	69,798,795	99,87			214	0,0014			3400	0,00014

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 69,798,795 ширхэг хувьцаа буюу **99,87 хувь**, татгалзсан – 214 ширхэг хувьцаа буюу 0,0014 хувь, түдгэлзсэн - 3400 ширхэг хувьцаа буюу 0,0014 хувь байна. Саналын эрхийн 17,855 ширхэг хувьцаатай 18 ширхэг хувьцаа эзэмшигчдийн саналыг хуудсыг хүчингүйд тооцов.

3. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг кумулятив аргаар сонгох” асуудлаар:

Ердийн гишүүнд нэр дэвшигч	Кумулятив аргаар санал өгсөн саналын эрхийн тоо
1.П.Батсайхан	69,804,819
2.П.Батчимэг	69,763,520
3.Б.Батбаяр	69,757,573
4. Ц.Ганчимэг	124,594
5. Громов.С.Б	69,758,778
6. Хьюго Баррет	69,732,863
7.Тревис Хамилтон	69,699,432

Үүнээс ТУЗ-ийн гишүүнд П.Батсайхан, П.Батчимэг, Б.Батбаяр, Громов.С.Б, Хьюго Барретт, Трэвис Хамилтон нар сонгогдов.

Саналын эрхийн 46,737 ширхэг хувьцаатай 21 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчингүйд тооцов.

Хараат бус гишүүнд нэр дэвшигч	Кумулятив аргаар санал өгсөн саналын эрхийн тоо
1.Тревор О'Хой	69,749,392
2. Руперт Пёрсер	69,099
3.Ж.Үнэнбат	69,798,875
4. Карло Радикати	69,705,053

Үүнээс ТУЗ-ийн хараат бус гишүүнд Тревор О'Хой, Ж.Үнэнбат, Карло Радикати нар сонгогдов.

Саналын эрхийн 46,352 ширхэг хувьцаатай 21 ширхэг хувьцаа эзэмшигчдийн саналыг хуудсыг хүчингүйд тооцов.

Хурлын шийдвэр:

Хурлын дарга, Гүйцэтгэх захирал **Ц.Эрдэнэбилэг**: АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 2 тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. АПУ ХК-ийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор шийдвэрлэв.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр П.Батсайхан, П.Батчимэг, Б.Батбаяр, Громов.С.Б, Хьюго Барретт, Трэвис Хамилтон, хараат бус гишүүнээр Тревор О'Хой, Ж.Үнэнбат, Карло Радикати нарыг сонгов. Сонгогдсон гишүүддээ амжилт хүсье гэснээр ээлжит хурлыг хаав.

Хурал 17 цаг 20 минутад дуусав.

ХЯНАСАН:

Хурлын дарга,

АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал  Цэвээнжавын Эрдэнэбилэг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга  Чадраабалын Ариунсан